

АРД ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2023 оны 4 сарын 29-ний өдөр

Хурлын байршил: Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Нийслэлийн Соёлын Төв Өргөөний танхим

Хурал эхэлсэн цаг: 10 цаг 30 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга О.Одбаяр

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 15,609,954 ширхэг буюу 62.44 хувь
Хурлаар хэлэлцэх асуудал:

1. 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2021 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайлан танилцуулах;
3. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

Тэмдэглэл:

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч даатгуулагч та бүхний энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье. Та бүхэндээ хурлын үйл ажиллагаандаа идэвхтэй оролцож өөрсдийн санал бодол Ард Даатгал ХК-ийн цаашдын үй ажиллагаатай холбон цаашдын хөгжлийн талаарх санал санаачилгаа хэлж идэвхтэй оролцохыг хүсч байна.

2022 он эдийн засгийн тогтворгүй, тодорхойгүй нөхцөл байдалд байсан хэдий ч бид түүхэн дээд хураамжийн орлогыг бүрдүүлэн хүнд хэцүү жилд ашигтай ажиллан хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг хадгалан амжилт бүтээлээр дүүрэн үдлээ. Тайлант хугацаанд компанийн хувьд 2021 оны хөрөнгийн зах зээлийн өсөлтийн дараах уналтын үед үнэ цэнийг хадгалж үлдэх, тогтворжуулан цаашид өсөлт үзүүлэх нөхцлийг бүрдүүлэхийн төлөө ажилласан жил байлаа.

Ард Даатгал ХК-ийн хувьд 2018 онд нээлттэй хувьцаат компани болсноос хойш жил бүр МХБ-ийн ТОП 20 индекст багтан МХБ-ийн 1-р ангиллын хувьцааны шаардлагыг бүрэн хангаж ажилласаар байна.

Та бүхэнд Ард Даатгал ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан тайлан зэргийг танилцуулахын зэрэгцээ ТУЗ хийж бүтээсэн ажлаа дүгнүүлэхээр танилцуулга бэлдээд байна.

Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал үүгээр нээж байгааг та бүхэнд мэдэгдье. Мөн өнөөдөр хуралдаа биеэр ирж амжаагүй хувьцаа эзэмшигчид, эсвэл компанийн үйл ажиллагааг сонирхож буй, эсвэл хувьцаа эзэмшигч болохыг сонирхож байгаа иргэд компанийн сошиал хаяг (<https://www.facebook.com/ArdInsurance/videos/537000408585442>)-р цацагдаж буй live-р орж хуралд оролцох боломжтой.

Одоо та бүхэнд тооллогын комисс хурлын ирцийн талаарх мэдээллийг өгнө. Хурлын ирцийг танилцуулъя.

Тооллогын комиссын дарга Б.Баттулга: Сайн байцгаана уу? Ард даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол 2023 оны 4 сарын 29-ний өдөр дугаар 23/01 Хувьцаа эзэмшигчдийн ирцийн баталгаажилт.

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Саналын эрх бүхий энгийн хувьцааны 15,609,954 ширхэг буюу 62.44 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна.

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болж байна. Баярлалаа.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Тооллогын комисст баярлалаа. Ирц хүрсэн учраас хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг уншиж танилцуулъя.

Хурлын дэг:

- | | |
|--|-------|
| ★ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх | 10:30 |
| ★ Хурлын ирц танилцуулах | |
| ★ Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал танилцуулах | |
| ★ Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх | 10:50 |
| ★ 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах; | |
| ★ 2022 онд олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах; | |
| ★ 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; | |
| ★ Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох; | |
| ★ Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт | 11:50 |
| ★ Санал авах | 12:00 |
| ★ Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах | 12:10 |
| ★ Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж, Хурлыг хаах | 12:20 |

Танилцуулсан:

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Өнөөдрийн хуралд ирсэн нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Ард Даатгал ХК-ийн хувьд дээд удирдах нэгж бол хувьцаа эзэмшигчдийн хурал, ХЭХ-с сонгогдсон 9 гишүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл ажилладаг бөгөөд ТУЗ нь ердийн зургаан, хараат бус гурван гишүүнтэйгээр ажилладаг. Мөн Төлөөлөн удирдах зөвлөл маань 3 хороотой ажилладаг бөгөөд Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Аудитын хороо гэсэн 3 хороотой. Компани маань нийтдээ 95 орчим ажиллагсадтай Даатгалын газар, Эрсдэлийн удирдлагын газар, Санхүү удирдлага, үйл ажиллагааны газар гэсэн гурван газартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн гурван жил Грант Торнтон Аудит компани манай санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийж дүгнэлт өгч ажиллаж байгаа бөгөөд Компанийн хувь Эерэг дүгнэлттэй ажиллаж байна. Өнгөрсөн онд 1 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгож ажилласан бөгөөд ҮЦГХТ дэх хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан байна. Сүүлийн 2 жил цар тахлын нөлөөний үед олон улсын аялалын даатгалд Ковидын хамгаалтгүй байсан бид өнгөрсөн онд тус бүтээгдэхүүний хамгаалтанд Ковидын хамгаалалт

анх оруулж 50 мянган доллар хүртэлх хамгаалттай болж зах зээлд нэвтрүүлсэн. 2022 оны 4 сарын 30-нд Хувьцаа эзэмшигчдийн хурал хийж зохих шийдвэрүүдийг гаргаж ажилласан. Хөрөнгө оруулагч үндэстэн 2022 чуулганд амжилттай оролцсон. Бид даатгалын боловсон хүчинг бэлдэх тал дээр идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай гэж үздэг бөгөөд Их дээд сургуулиудтай хамтран даатгалын чиглэлээр эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулж ажилласан. Мөн даатгалын бүртгэлийн үндсэн системээ шинэчлэн веб суурьтай ERP шинэ системийг нэвтрүүлсэн бөгөөд ингэснээр орчин үеийн шинэ технологитой уялдан ажиллах, бүх төрлийн онлайн гүйлгээнүүдийг холбох боломжтой олон давуу тал үүсгэж байна. Энэ ч хүрээнд нөхөн төлбөрийн материалыг АрдАпп-р дамжуулан авах боломжтой болсон бөгөөд энэ нь даатгалын үндсэн ERP системтэй шууд холбогдон ажиллаж харилцагч, даатгуулагч нарт маань цаг хугацаа, хөрөнгө хэмнэж байна. 2022 онд Ард Даатгал ХК нь 475 сая төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл, 1.2 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна. Оны сүүлээр Амар Даатгал ХХК-тай хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэсэн бөгөөд энэ хүрээнд даатгалын зах зээлд шинэлэг, иновацлаг бүтээгдэхүүнийг ард иргэдэд танилцуулья, хамтарч ажиллая, даатгалын зах зээлийг шинэ түвшинд гаргая гэсэн зорилгын хүрээнд санамж бичиг байгуулсан.

Санхүүгийн хувьд голлох үзүүлэлтийг дурдахад нийт хөрөнгө 35.6 тэрбум төгрөг болж өнгөрсөн жилийн мөн үеийн эцсээс 17 хувиар өссөн байна. Хувьцаа эзэмшигч та бүхний өөрийн хөрөнгө буюу эздийн өмч 16.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хураамжийн орлого 36 хувиар өсч 22.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс цэвэр хураамжийн орлого 31 хувиар өсч 17.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Даатгалын компани ганц манай улсад ч төдийгүй олон улсад үндсэн даатгалын үйл ажиллагааны ашиг хийдэггүй бөгөөд хөрөнгө оруулалтын багцаа зөв удирдсанаар ашигаа бүрдүүлж ажилладаг. Нийт нөөц сан 14.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 26 хувиар өссөн. Өнгөрсөн оны хувьд эдийн засгийн тодорхойгүй байдал, Орос-Украины дайн, Ковидын дараах эдийн засгийн удаашралт, тээвэр зуучийн хүндрэл зэргээс хамаарч олон сөрөг үр дагаврууд байсан хэдий ч бид 737 сая төгрөгийн ашигтай ажилласан. Нийт нөхөн маань 5.0 тэрбум төгрөгөөс 7.8 тэрбум төгрөг болж өсч 8,000 гаруй даатгуулагчид нөхөн төлбөр олгосон. Энэхүү өсөлтөд гол нөлөөлсөн хүчин зүйлүүдийн хувьд сэлбэг хэрэгслийн үнийн өсөлт, эмнэлэг үйлчилгээ, эмийн үнийн өсөлт, хохирлын тоо нэмэгдсэн зэрэг нөлөөллүүд гарсан байна. Гэсэн хэдий ч бид хохирлын харьцааг 40.2 хувьд, зардлын харьцааг 59.6 хувьд барьж ажилласнаар хосолсон харьцаа 99.8 хувь гарч үндсэн үйл ажиллагаанаас тодорхой хэмжээний ашигтай ажилласан байна. Төлбөрийн чадварын хувьд СЗХ-с 110-с дээш байх шаардлага байдаг бөгөөд аудитлагдсан тайлангаар 118 хувьтай гарч төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаж байна.

Орлого үр дүнгийн тайланг дэлгэцэнд танилцуулж байна. 2022 онд бид нийт 8,000 гаруй даатгуулагчид 7.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. 2021 онд энэ дүн 5,800 байсан бол нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 2,200-р нэмэгджээ. Бид татвар төлөхийн өмнө нийт 903 сая төгрөгийн ашигтай ажиллаж үүнээс татварт 166 сая төгрөгийг бүртгэсэн. Ингээд цэвэр ашиг нийт 737 сая төгрөгтэй гарсан.

Санхүүгийг тайланд энэхүү слайдад харагдаж байна. Нийт хөрөнгийн хувьд 35.6 тэрбум төгрөг, үүнээс 24.2 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын багцад байршиж байна. Авлаг 6.4 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнд даатгалын хураамжийн авлага, буруутай этгээдээс авах авлагууд багтдаг бөгөөд хугацаа хэтэрсэн муу авлага байхгүй бүгд хэвийн авлагаар бүртгэгдэж байна. Нийт нөөц сан 14.7 тэрбум төгрөг, эздийн өмч 16.7 тэрбум төгрөг хүрсэн байна. Гол өөрчлөлтийг харах юм бол үндсэн хөрөнгө буурсан байгаа бөгөөд компанийн

эзэмшилд байсан үндсэн хөрөнгийг борлуулснаар үндсэн хөрөнгө өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд ТОП 15 хувьцаа эзэмшигчид дунд манай компанийн 80 орчим хувь нь байршиж байдаг бөгөөд тус хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлд энд харагдаж байна. Хамгийн том хувьцаа эзэмшигч Ард санхүүгийн нэгдэл ХК нийт хувьцааны 45.4 хувийг эзэмшдэг байна. Энэ хүснэгтээс та бүхэнд харагдаж байгаа байх хувьцаа өнгөрсөн жилийн хувьд Үнэт цаасны компаниуд, Сангууд манай хувьцааг сонгож хөрөнгө оруулалт хийх нэмэгдсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр манай хувьцаа эзэмшигчдийн тоо 10,030 болсон байна. Хувьцааны арилжааны хувьд 2022 онд 2.6 сая ширхэг хувьцаа, нийт 2.4 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд дээд үнэ 1,350 төгрөг, доод үнэ 685 төгрөг хүрсэн бол жилийн арилжааны сүүлийн өдөр 929 төгрөгөөр хаагдсан байна. Ингэснээр 2022 он жилийн эцсийн байдлаар компанийн үнэлгээ 23.2 тэрбум төгрөг болсон байна.

Манай санхүүгийн үйл ажиллагааны тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт өгсөн Грант Торнтон Аудит ХХК-ийн партнёр Н.Эрдэнэцог таныг урьж байна.

Грант Торнтон Аудит ХХК Н.Эрдэнэцог: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Эрдэнэцог гэдэг. Грант Торнтон Аудит ХХК-ийн аудитын партнёр, Ард даатгал ХК-ийн аудитын гэрээт ажлын партнёр. Манай Грант Торнтон Аудит бол дэлхийн топ 6 аудитын зөвлөх үйлчилгээний компанийн нэг бөгөөд Монгол улсад 2019 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд сүүлийн гурван жил Ард Даатгал ХК-д санхүүгийн тайланд аудит хийж ажиллаж байна. Ард Даатгал ХК нь даатгалын салбарт нилээд жин нөлөө дарахуйц компанийн нэг бөгөөд аудитын гэрээ байгуулснаас хойш аудитын төлөвлөгөө, хуваарь, завсар үеийн аудитын 2022 оны 11 сард хийж, жилийн эцсийн аудитыг санхүүгийн тайлан гарснаас хойш хийж дүгнэлт гаргаж ажиллаа. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд дүгнэлтээ танилцуулсан бөгөөд өнөөдөр хувьцаа эзэмшигчид та бүхэнд танилцуулж байна. Аудитын багийн хувьд найман хүний бүрэлдэхүүнтэй ажилласан бөгөөд багийн гишүүд тус слайдад харагдаж байна. Аудитын цар хүрээний хувьд аудитын үүрэг хариуцлага компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зохицуулагч байгууллагаас тогтоосон бусад мэдээлэл үнэн зөв эсэх байдаг бол удирдлагын үүрэг хариуцлага СТОУС, холбогдох дүрэм, журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих бэлтгэх, тасралтгүй байх суурийг хэрэглэх байдаг.

Аудитын явцад бид томоохон 3 асуудал дээр анхаарал хандуулсан. Тэр нь компани тайлант жилд удирдлагын шийдвэрээр өмчид оруулсан хөрөнгө оруулалтыг борлуулахад бэлэн үнэт цаасаар ангилан бодит үнэ цэнийн хэмжилтийг бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнасан. Аудитын тайлангийн гол асуудалд Даатгалын нөөц сан-Актуар тооцоолол бөгөөд Даатгалын үйл ажиллагаа эрхлэгч компанийн тухайд Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02-дугаар тогтоолоор батлагдсан "Даатгалын багц дүрэм"-ийн 3 дугаар хавсралт "Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын дагуу актуар тооцооллоор даатгалын нөөц санг зохистой хэмжээгээр байгуулан ажилласан байна. Зохистой харьцааны хувьд Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмын 2.18-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс

илүү байвал зохино” гэснийг Ард Даатгал ХК-ийн хувьд 118 хувьтай гарч бүрэн хангаж ажилласан байна. Хараат бус аудиторын дүгнэлтийн хувьд бид Эерэг дүгнэлт өгсөн байна. Ард даатгал ХК олон нийтийн компани, нөгөө талаасаа Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай этгээд гэдэг утгаараа Санхүүгийн зохицуулах хороо болон Сангийн яамнаас баталсан даатгалын багц дүрэм, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмын дагуу санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэлт өгсөн байгаа. Баярлалаа.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хурлын дэгийн дагуу дараагийн асуудлыг та бүхэнд танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны цэвэр ашгаас ногдол ашиг олгох тухай шийдвэрийг 2022 оны 2 сарын 16-ны өдөр ТУЗ-ийн эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрээр 2021 оны цэвэр ашгаас нийт 1.0 тэрбум төгрөгийн мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 40 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу 2022 оны 7 сарын 28-ны өдөр ҮЦТХТ-тэй ногдол ашиг тараалгах гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн ҮЦТХТ дэх хувьцааны дансаар дамжуулан ногдол ашгийг бүрэн олголоо.

Ногдол ашгийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2022 оны 4 сарын 4-ний байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо

Олгосон хэлбэр	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Хувьцааны тоо	Ногдол ашиг	Татварын дараах ногдол ашиг	Хувь
ҮЦТХТ	9,954	9,910,707	396,428,280	370,622,840	40%
Хуулийн этгээд	15	2,121,998	84,879,920	76,391,928	8%
Дотоодын иргэн	9,914	7,498,704	299,948,160	284,950,752	30%
Гадаадын иргэн	25	290,005	11,600,200	9,280,160	1%
Компаниас шууд олгосон	7	15,089,293	603,571,720	545,544,192	60%
Хуулийн этгээд	6	13,924,471	556,978,840	501,280,956	56%
Дотоодын иргэн	1	1,164,822	46,592,880	44,263,236	5%
Гадаадын иргэн	-	-	-	-	0%
НИЙТ ДҮН	9,961	25,000,000	1,000,000,000	916,167,032	100%

2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэнд манай ТУЗ-ийн дарга О.Одбаяр танилцуулна.

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: 2022 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөл өнгөрсөн хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Одбаяр, ердийн гишүүнээр Г.Уянга, Б.Золбоо, Г.Цогбадрах, С.Оргил, Ч.Ганзориг нар ажилласан бол хараат бус гишүүдээр З.Ариун, И.Сэр-Од, Б.Болорчимэг нар ажилласан бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Г.Баярбат нар ажиллаа. 2022 онд ТУЗ нь 5 удаа ээлжит хурал, 1 удаа эчнээ санал хураалтаар хуралдан шийдвэрүүд гарган ажилласан бөгөөд нийт 23 шийдвэр гаргаж ажиллаа. ТУЗ-с гарсан онцлох шийдвэрүүдийг дурьдвал. Үүнд:

- ✓ 2021 оны цэвэр ашгийн дүнгээс 1 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгох
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- ✓ 2021 оны аудитлагдсан тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлт гарган батлах тухай
- ✓ Гүйцэтгэх захирлын үнэлгээ батлах тухай
- ✓ Хуулийн нийцэл хариуцсан ажилтан томилох тухай
- ✓ ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тухай
- ✓ ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээний аргачлал батлах тухай
- ✓ 2023 оны компанийн төсөв, төлөвлөгөө батлах тухай
- ✓ Хөрөнгө оруулалт, Давхар даатгалын төлөвлөгөө батлах тухай гэсэн шийдвэрүүд гарсан байна.

ТУЗ нь гурван хороонд хуваагдан ажиллаж байгаа бөгөөд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдээр Б.Болорчимэг, Ч.Ганзориг, З.Ариун, нарийн бичгийн даргаар нь Батцэнгэл нар ажиллаж байгаа ба 3 удаа хуралдаж 13 асуудал хэлэлцэн ажилласан байна. Санхүү, эрсдэл хөрөнгө оруулалтын хорооны гишүүд Б.Золбоо, С.Оргил, Г.Цогбадрах, нарийн бичгийн даргаар Г.Баярбат нар ажиллаж байгаа бөгөөд 4 удаа хуралдаж 22 асуудал хэлэлцсэн байна. Аудитын хороо Г.Уянга, З.Ариун, И.Сэр-Од, нарийн бичгийн даргаар Бямбасүрэн нар ажиллаж байгаа бөгөөд 3 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцсэн байна. Ард даатгал ХК-ийн удирдлагын баг бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө батлах, санхүүгийн тайлан хэлэлцүүлгийг батлах, аудитын дүгнэлтийг хянах зэрэг бүх үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөл амжилттай удирдан зохион байгуулсан гэдгийг нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хэлмээр байна. Ард даатгал ХК дээр хувьцаа эзэмшигчдээ төлөөлөөд нэмж нэг зүйл хэлэхэд хараат бус гишүүд маань хараат бус үйл ажиллагаагаа маш сайн явуулдаг, компанийн засаглалын хувьд маш тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, тогтвортой өсөлтийг үйл ажиллагаандаа үзүүлж байгаа сайн засаглалтай компани гэдгийг хэлэхэд таатай байна.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч, даатгуулагчид болон хамтран зүтгэгчид та бүхэнд компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж байна.

2022 оны хувьд дэлхий даяар эдийн засгийн байдал тогтворгүй, Ковидын дараах эдийн засгийн сэргэлт удааширсан, Орос, Украины дайнаас шалтгаалсан эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн онцгой үйл явдлуудаар дүүрэн жил болсон хэдий ч Ард Даатгал ХК-ийн хувьд өөрсдийн нөөц боломжоо ашиглан хураамжийн орлогыг өнгөрсөн оны мөн үеэс 36 хувиар өсч, төсвөөс 10 хувиар давуулан нийт 22.3 тэрбум төгрөг хуримтлуулснаар түүхэндээ хамгийн өндөр хураамжийн орлоготой ажиллаж, хосолсон харьцаа 99.8 хувьтай гарч, цэвэр ашиг 737 сая төгрөгт хүрч ажилласан байна. Тайлант онд даатгалын үндсэн системийн шинэ хувилбар нэвтрүүлж, нөхөн төлбөр хүлээн авах, санхүүгийн гүйлгээг хурдасгах, даатгалын бүртгэл сайжруулж, бусад систем, аппликешнтэй холбох, иргэдийн даатгал, нөхөн төлбөрийн үйл ажиллагааг цахимжуулах зэрэг цоо шинэ боломжуудыг зах зээлд бий болгон ажиллаа. ТУЗ нь улирал бүр компанийн дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлж буй арга хэмжээ, төлөвлөгөөт ажлуудын үр дүнг хэлэлцэж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэх, санал, шүүмжлэл хэлж, засаж залруулж ирсэн. ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүнд сэтгэл хангалуун байгаа ба компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлд **ХАНГАЛТТАЙ** гэсэн дүгнэлтийг хийж, компанийн Гүйцэтгэх захиралд бүрэн итгэл

хүлээлгэн ирээдүйд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхэд ТУЗ-ийн зүгээс бүх талаар дэмжин ажиллах болно.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал байгаа бөгөөд нэр дэвшигчдийн танилцуулгыг та бүхэнд хийе. Ердийн гишүүнд дараах нэр дэвшигчид дэвшсэн байна. Үүнд:

1. О.Одбаяр – Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Олимпын хорооны дэд ерөнхийлөгч бөгөөд 2015 оноос хойш Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.
2. Г. Уянга – Ард Пропертиз ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Тэнгэрлиг медиа групп ТУЗ-ийн даргаар ажилладаг.
3. Ч.Ганзориг – Ард Экс ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг бөгөөд 2016 оноос хойш Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.
4. Б.Золбоо – Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал бөгөөд 2016 оноос хойш Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.
5. С.Оргил – Мост Финтек ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажилладаг.
6. Г.Цогбадрах – Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажилладаг.

Хараат бус гишүүнд дараах нэр дэвшигчид дэвшсэн байна. Үүнд:

1. З.Ариун – Улаанбаатар дахь Америк сургуульд Зөвлөхөөр ажилладаг.
2. Б.Болорчимэг – Өрөг.МН Үүсгэн байгуулагч, Захиралаар нь ажилладаг.
3. И.Сэр-Од – Монголын бизнес мэдээллийн бааз Үүсгэн байгуулагч, Захиралаар ажилладаг.
4. З.Оюунцацрал – СЭЗИС-ийн Ахисан түвшний Профессор.
5. Т.Билгээ – Эрдэнэс Баянбогд ХХК-ийн Уул уурхайн газрын захирал.
6. Д.Галхүү – PWC аудит Аудитор

ТУЗ-д дээрх 12 нэр дэвшигч дэвшсэн байгаа бөгөөд тус хурлаас 9 гишүүнийг сонгож ТУЗ-д гишүүнээр сонгохоор байна. Нийт нэр дэвшигчиддээ бүгдэд нь амжилт хүсье. Хувьцаа эзэмшигчид маань санал өгөх заавартай сайн танилцаарай.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан асуух асуулт болон хэлэх санал байна уу? За онлайнаар ирсэн асуултууд ирсэн байна үүнд хариулья.

Онлайнаар ирсэн асуулт: Даатгалын бизнесийг өргөжүүлэх зорилтууд бий юу?

Хариулт Г.Цогбадрах: Мэдээж байлгүй яахав. Дотоодын даатгалын зах зээл маань өөрөө өсөх бүрэн боломжтой хөгжиж буй орнуудад ДНБ-н даатгалын зах зээлийн хураамжтай нь харьцуулсан харьцаа 3-с дээш байдаг бол хөгжингүй орнуудад 8-10 хувь байдаг бол манай улсад 0.5-0.6 хувьтай байдаг. Тэгэхээр даатгалын зах зээлд өсөх боломж маш их бөгөөд иргэдийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх ажлууд хийх шаардлагатай байдаг. СЗХ-с зүгээс энэ жилийг даатгалын боловсрол олгох жил болгон зарласантай холбоотой даатгалын компаниуд ч нэгдэн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулан ажиллаж байна. Мөн АрдАпп-р даатгал хийх боломжуудыг бид бүхэн нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд тун удахгүй Албан журмын даатгал АрдАпп-р хийх боломжтой болохоор байна.

Онлайнаар ирсэн асуулт: Хараат бус гишүүнд заалнаас нэр дэвших боломжтой юу?

Хариулт Г.Цогбадрах: Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах зар хугацаатай зарлагдан нэр дэвшигчдийг авч ХЭХ-ийн материалд орж танилцуулагддаг бөгөөд заалнаас ТУЗ-д нэр дэвших боломжгүй байдаг.

Та бүхэнд өөр санал асуулт асуулт байна уу? За асуулт байхгүй бол санал хураалт үүгээр эхэлж байна. Та бүхэн саналаа идэвхтэй өгөөрэй баярлалаа.

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: За санал хураалт дууссан байна. Одоо тооллогын комиссын дарга Алтансүх санал хураалтын дүнг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Б.Баттулга: Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №23/02

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай санал хураалтад 15,609,954 ширхэг буюу 62.44 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 1.1. Зөвшөөрсөн 15,539,380 ширхэг буюу 99.55%;
 - 1.2. Татгалзсан 0 ширхэг буюу 0.00%;
 - 1.3. Түдгэлзсэн 0 ширхэг буюу 0.00% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

2. Хүчингүй болсон саналын хуудасны тоо:

2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтад санал өгсөн хувьцаа эзэмшигчдээс хүчингүй санал гараагүй болно.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №23/03

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйл 77.1 болон 77.2 дугаар хэсгийг үндэслэн. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох тухай санал хураалтад 15,609,954 ширхэг энгийн хувьцаа буюу 62.44 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо
Ердийн гишүүд		
1	О.Одбаяр	15,496,437

2	Г.Уянга	15,719,525
3	Ч.Ганзориг	15,489,939
4	Б.Золбоо	15,496,529
5	С.Оргил	15,466,530
6	Г.Цогбадрах	15,533,916

2. Хүчингүй болсон саналын хуудасны тоо:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох тухай санал хураалтаас хүчингүй санал гараагүй байна.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №23/04

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйл 77.1 болон 77.2 дугаар хэсгийг үндэслэн. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох тухай санал хураалтад 15,609,954 ширхэг энгийн хувьцаа буюу 62.44 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо
---	--	-------------

Хараат бус гишүүд

1	З.Ариун	18,183,309
2	Б.Болорчимэг	14,299,369
3	Т.Билгээ	14,073,667
4	И.Сэр-Од	230,965
5	З.Оюунцацрал	6,926
6	Д.Галхүү	5,018

4. Хүчингүй болсон саналын хуудасны тоо:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох тухай санал хураалтаас хүчингүй санал гараагүй байна.

Тооллогын комиссын дарга Б.Баттулга: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: Тооллогын комиссын дарга Баттулга танд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалт амжилттай явж дүнгээ танилцууллаа. За одоо хурлаас гарсан шийдвэрийг та бүхэнд танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №01/22

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2022 оны 4 сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 21/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн удирдлагын багт талархлаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.БАЯРБАТ